



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/64

Рашаант сум

**Дархлаажуулалтын ажил
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын А/272 тоот захирамж, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.4, 9.5, 9.8, 9.8.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рашаант суманд малын Боом, ДХХ, Листерииоз, Энтербактериоз, Цусан халдвар, Галзуу, Сахуу өвчнөөс урдьчилан сэргийлэх мал сүргийг дархлаажуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтыг 2024 оны 04 дүгээр 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны хооронд үр дүнтэй зохион байгуулахыг мал эмнэлгийн нэгжийн малын их эмч (М.Оюунцэцэг, Ц.Зоригт, Ч.Наранцэцэг) нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтын талаар малчин иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн, малыг бэлэн байлгах, хашаа хавчиг бэлдүүлэх, дархлаажуулалтын ажил хийхэд шаардлагатай хүн хүчийг томилж зохион байгуулж хамтран ажиллахыг багийн Засаг дарга (С.Далай, Б.Мөнхнасан, П.Мөнхтүвшин, Б.Баянбаатар, Д.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ажлын явцад хяналт тавьж мал сүргийг дархлаажуулалтад хамруулах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Идэр)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж шаардагдах хөрөнгө санхүүг олгож ажиллахыг (Т.Отгонцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

D:\anasaa bichig hereg\A-Zax.doc

6706011118